

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2022 оны 10 дугаар сарын мэдээ

2022.10.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: Монголын багш нарын 56, Дэлхийн багш нарын 28 дах баярын өдрийг тохиолдуулан боловсролын байгууллагад оруулж буй хөдөлмөр зүтгэлийг үнэлж зарим багш нарыг ИТХ-ын даргын шагналаар шагнаж урамшууллаа.

Аймгийн ИТХ-ын ажлын албаны даргын удирдамжийн дагуу Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдсэн.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 18 албан бичиг ирсний 2 нь хариутай хугацаанд нь хүргүүлсэн.

Бүх нийтийн цэвэрлэгээг сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын 24-30 өдрүүдэд зохион байгуулахаар хуваарийн дагуу хийгдэж байна.

Мөн сумын хэмжээнд золбин нохой олширч хүн, амьтны паразит өвчин гарах, хүн рүү дайрч гэмтэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор золбин нохой устгах ажлыг зохион байгууллаа.

Монголын багш нарын 56, Дэлхийн багш нарын 28 дах баярын өдрийг тохиолдуулан боловсролын байгууллагад оруулж буй хөдөлмөр зүтгэлийг үнэлж зарим багш нарыг сумын засаг даргын шагналаар шагнаж урамшууллаа.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр:

2022 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ.

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг, тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилт хуваарийн дагуу эхний 9 сар бүрэн олгогдсон.

Байгууллагын өр авлага ,төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн .

Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

Төсөвт байгуулага, татварын орлогын дансанд гарын үсгийн баталгааг авч нотариатаар баталгаажуулж , цахим мэдээллийн системд оруулж ажиллаа.

ОНХСан , малын тоо толгойн албан татвараар хийгдэх ажил болон засаг даргын мөрийн хөтөлбөрөөр хийгдсэн ажлуудын санхүүжилт хуваарийн дагуу олгогдож цаг хугацаандаа хийгдсэн.

Төсвийн газруудын 2022 оны 3-р улирлын санхүүгийн тайлан хугацаанд нь e-balance программд шивж сумын нэгдсэн тайлан гаргаж аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажиллаа.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Сумын засаг даргын тамгын газраас “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулж, өөрсдийн үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчилж, иргэдийн гомдол санал хүсэлтийг сонсож, шийдвэрлэж болохуйц санал хүсэлтийг газар дээр нь шийдвэрлэж ажиллалаа. Өдөрлөгөөр давхардсан тоогоор 52 иргэнд 6 төрлийн үйлчилгээг үзүүлж, нийгмийн даатгал, хөдөлмөр халамж үйлчилгээ, байгаль орчин болон бусад салбарт хамаарах 96 ширхэг гарын авлага, тараах материал тараагдаж, зөвлөгөө мэдээлэл өгөгдсөн байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Ерөнхий боловсролын сургууль: 09 дугаар сарын 26-нд “Хувь хүний ур чадвар энтрепернершип боловсрол олгох” төслийн үйл ажиллагааг эцэг эхчүүдэд танилцуулах өдөрлөгийг зохион байгууллаа.

Монгол улсын начин Жанцангийн Чулууны нэрэмжит өсвөр үеийн үндэсний бөхийн барилдаанд 9в ангийн сурагч Б.Бөхбат хүрэл медаль хүртлээ.

Эрүүл мэндийн боловсрол, түүний дотор жендэрийн агуулгыг багш нарт хүргэх, үндэсний чадавхыг бэхжүүлэх сургалтад биологи, эрүүл мэнд болон 4-5 дугаар анги удирдсан багш нар хамрагдлаа.

2020-2021 оны хичээлийн жилийн хаврын элсэлтийн ESEL хөтөлбөрийн “Тэмүүлэл” баг “Гар урлал” төслийн санхүүжилтээр 8 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 9 сарын 28, 29-ны өдрүүдэд Зүүн бүсийн 3 аймгийн баялаг бүтээгчдийн үзэсгэлэн худалдаанд оролцлоо.

ЕБСургуулийн нийгмийн ажилтан 6-9 дүгээр ангийн 268 сурагчидад “Үе тэнгийн дээрэлхэлт дарамт, шахалт гэж юу вэ?” сургалтыг зохион байгууллаа. Мөн “Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх” аян зохион байгуулах агуулга, арга зүйн цахим сургалтад нийгмийн ажилтан, бага ангийн багш, дотуур байрын багш нар хамрагдсан.

10 дугаар сарын 21-ны өдөр “Хөөсний баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүллээ. Уг өдөр мэргэжлийн багш болон сурагчид хамтран байгууллагын орчны цэвэрлэгээ үйлчилгээг хийв.

Нийгмийн ажилтан 9 дүгээр ангийн сурагчдын эцэг эх, асран хамгаалагч нартай уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж 3 бүлгийн 94 хүүхдүүдийн эцэг эх оролцлоо.

Соёл: Тухайн сард соёл урлагийн 7 үйл ажиллагааг зохион байгуулж 892 иргэн бусад үйл ажиллагаанд 372 иргэн тус тус хамрагдсан.

“Түүх, соёлын үл хөдлөх дурсгал” - ын улсын тооллогыг аймгийн ажлын хэсэгтэй хамтран сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилогдон 09 сарын 27 -с 10 сарын 04- ны хооронд улсын бүртгэлд байсан 54 газрын түүх соёлын үл хөдлөх дурсгалыг тоолж, шинээр 5 булш, 2 хөшөө дурсгал, 3 хадны бичиг, сүг зураг, тамга тэмдэгтэй дурсгалт газруудыг 7 хоногийн хугацаанд нийт 1184 км замыг туулж сумын нутаг дэвсгэрт байрлах нийт 64 түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг тоолж

дуусгаж, тооллогын хээрийн маягтыг аймгийн соёл урлагийн газарт цаг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас “Соёлын биет бус өвийн анхдугаар үзлэг, бүсчилсэн судалгаан” – ы баг, аймгийн Соёл урлагийн газартай хамтран 10 сарын 23, 24 – ны өдрүүдэд тус суманд соёлын биет бус өвийн үзлэг, судалгааг зохион байгуулж ажилласан. Уг судалгаанд эх хэл, аман уламжлал илэрхийллийн төрөлд өндөр настан Г. Гунаасүрэн, ардын сурган хүмүүжүүлэх арга ухаан төрөлд ахмад багш Г. Төмөрхуяг, морин хуурын дарьганга татлагаар С. Цэнд, адуу маллах арга ухаан, хурдан морь шинжих, уяа сойлгоор аймгийн алдарт уяач Д. Пүрэвсүрэн, П. Амгаланбаатар, уламжлалт морь хатгах арга ухаанаар Ч. Буянхүү, монгол зургийн урлалаар М. Шагдаржав, ургамалын зүйлээр анагаах арга ухаан, бариа засал, уламжлалт уран хатгамал, оёдолын урлалаар Г. Даамаа нарыг хамруулан судалгаа авч, дүрс бичлэг хийж, баримтжуулсан.

Соёлын төвийн номын сан нь ажлын 8 цагаар тогтмол ажиллаж уншигч үйлчлүүлэгчдэд гэрээр болон танхимаар ном олгож ажиллаа. Байнгын уншигч 36, ирэгсэд 151 хүнд 169 ном гэрээр олгож 8 хүнд утсаар болон амаар лавлагаа өгч 11 татгалзал бүртгэлээ.

Соёлын сайдын 2022 оны 06 сарын 27-ны өдрийн А/212 тоот тушаал, Соёл урлагийн газрын даргын 2022 оны 09 сарын 27-ны өдрийн 178 тоот албан бичгийн дагуу нийтийн номын сангийн сан хөмрөгийг хүүхдэд зориулсан хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон ном зохиолоор хангах зорилгоор батлагдсан төсвийн хэмжээнд тааруулан “Нийтийн номын сангийн сан хөмрөгийг бүрдүүлэх удирдамж”-ийн дагуу “Номын коллектор” ХХК – аас хүүхдийн ном хэвлэлийг шууд худалдан авлаа.

Хүүхдийн номын баяжилтыг: Танин мэдэхүй сэтгэхүй хөгжүүлэх
Монголын болон дэлхийн хүүхдийн уран зохиол
Түүх ёс заншил
Байгаль нийгэм мэдээлэл харилцаа техник технологи
зэрэг ангилалын 25 нэр төрлийн 44 ширхэг номоор фондын баяжилт хийгдлээ.

Цэцэрлэг: Багш нарын ур чадвар, арга зүйг нэмэгдүүлж шинэ шинэлэг санаа, оновчтой төлөвлөлт, шилдэг арга зүйгээс нь хамтдаа суралцаж бусдад түгээх зорилготой “Нээлттэй сургалт, үйл ажиллагааг бүлгийн 9, хөдөлгөөн эрүүл мэнд-1, хувилбарт сургалт-1, туслах-8 багш нар оролцож энэ сарынхаа үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.

Ахлах, бэлтгэл бүлгийн нийт 158 хүүхдүүдийн дунд “АЛТАН НАМАР” спорт өдөрлөгийг 5 төрөлд тэмцээнийг цэцэрлэгийн заах аргын нэгдэл болон хөдөлгөөн эрүүл мэндийн багш нар хамтран зохион байгуулж, хурд хүч авхаалж самбаагаа сорин амжилттай оролцсон хүүхдүүд болон бүлгийг шагнаж урамшуулсан.

Эко цэцэрлэг хөтөлбөрийн хүрээнд 5 сургагч багш бэлтгэгдэж ХАЛЗАН сумын хүүхдийн цэцэрлэг рүү түгээн дэлгэрүүлэлтийг хийж, мөн МАНДАРВАА-8 цэцэрлэгийн

эко багийн хамт олонтой хамтран ХҮРЭЛ ГЭРЭГЭ авах болзолын тайлангаа бүлгийн багш нарын хамт амжилттай гүйцэтгэсэн.

"Сүхбаатарын Өнгө" сонины 5 жилийн ойд зориулсан "НАЙРГИЙН ОРНЫ НАЙРАГЧ ХҮҮХДҮҮД" уран уншлагын уралдааныг байгууллагатаа 3-5 насны ангилалаар нийт 32 хүүхдийг хамруулан зохион байгуулж шалгарсан 5 настай 3 хүүхдийг баруун-Урт хотноо зохион байгуулсан 2-р шатанд нь амжилттай оролцуулсан.

“Хүүхэд төвт сургалтын арга зүй” сургалтад аргагүйч, бүлгийн багш нар нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй хамрагдлаа.

Эрүүл мэндийн төв: Нийт үзлэгт-805 урьдчилан сэргийлэх үзлэг – 464 амбулаторийн үзлэг-178, Больницод хэвтэн эмчлүүлсэн нийт – 30, дуудлага - 14 ирсэн дуудлага бүрийг хугацаа алдалгүй шийдвэрлэсэн. Жирэмсний хяналтанд нийт 10 эх орсноос эрт хяналт 10, АНЭ төрсөн эх – 4 эх төрсөн. Эх хүүхдийн эргэлт – 10, Эсийн шинжилгээ – 34, Хөхний үзлэгт – 70 эмэгтэйчүүд хамрагдсан.

Сэргээн засах эмчилгээний кабинетаар нийт 53, /давхардсан тоогоор/ лабораториор нийт 124 иргэн /давхардсан тоогоор/ үйлчлүүлснээс:

ЦДШ - 28

ШЕШ-44

Үе мөч - 17

Бруцеллёз – 5

Сериологи - 18

В С вирус - 21

Сахар – 30

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр: “Эрүүл Сүхбаатарчууд” аяны хүрээнд багийн эмч нар багаараа тойролт хийж эрүүл мэндийн даатгал төлөөгүй иргэдийг В С вирусын шинжилгээнд хамруулав.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: Хөдөлмөр халамжийн газраас “Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт”-ийн чиглэлээр орон нутагт ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй төсөлд нийгмийн халамж авч буй, хөдөлмөрийн чадвартай 20 иргэнийг ногоон байгууламжийн усалгаа арчилгаа, мод тарих арчлах ажилд хамрууллаа.

Намрын мод тарилтаар 7 000 ширхэг хайлаасыг А цэцэрлэгжүүлэлт ХХК-аас нийлүүлэн нийтийн эзэмшлийн талбайд тарилаа. Мод тарих ажлын зардалд 16 000 000 /арван зургаан сая/ төгрөг зарцуулсан.

Хөдөө аж ахуй: Баруун бүслүүр хоршоотой гэрээ хийж 1320 толгой үржлийн хонь, 2022 толгой үржлийн ямаанд намрын хувьслын ангилалт хийж ээмэгжүүлэн цахим программд шивэх ажлыг эхлүүлээд байна.

Шим ХХК-тай гэрээ хийж бактерийн бэлдмэл 1.5 тн – ыг татан авч, 5 багийн 600 га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготной микробиологийн аргаар тэмцэх ажлыг малчидтай хамтран зохион байгуулсан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” хөдөлгөөний хэрэгжүүлэх хүрээнд Эрдэнэцагаан суманд “Бүсийн аварга тогооч, зөөгчийн сургалт, ур чадвар 2022” тэмцээнд 10 тогоочийн хамт амжилттай оролцож, 8 тогооч 5 төрлөөр ур чадварын тэмцээнд оролцож, рестран зоогийн газрын төрөлд 2, 3 –р байр, хүүхдийн хоол төрөлд 3-р байр, зөөгчийн төрөлд 3-р байр, нарийн боов төрөлд 3-р байр, эмчилгээ сувилалын төрөлд Засаг даргын жуух бичиг, үдийн цай төрөлд Засаг даргын баярын бичгээр тус тус шагнагдсан.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн